



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.12.15 № 0219258

танай _____ -ны № _____ -т

Хэрэгжилтийн тайлан хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.14 дэх заалтад “Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороонд жил бүр байнгын хороо хэлэлцэнэ” гэж заасны дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайланг 2023 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар боловсруулж, хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт: хуудастай.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9762004848


ТАНИЛЦУУЛГА

1. Улсын нийт гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2023 оны 3-р улирлын байдлаар 34.0 тэрбум ам.доллартой тэнцэж байгаагаас 22.5 тэрбум ам.долларыг аж ахуй нэгжүүдийн гадаад өр, 7.9 тэрбум ам.долларыг Засгийн газрын гадаад өр, 2.0 тэрбум ам.долларыг Төв банкны өр, үлдсэн 1.6 тэрбум ам.долларыг арилжааны банкнуудын өр тус тус эзэлж байна.

Монгол Улсын нийт гадаад өрийн ДНБ-д харьцуулах харьцаа үзүүлэлт 2021 он хүртэл 200 хувиас өндөр байсан бол 2022 оноос эхлэн буурч 2023 оны 3-р улирлын байдлаар 191 хувьтай тэнцэж байна. Мөн энэхүү үзүүлэлтэд Оюутолгойн өр төлбөр орж тооцогдох бөгөөд үүнийг хасахад ДНБ-д эзлэх улсын нийт гадаад өрийн хэмжээ 117 хувьтай тэнцэж байна.

График №1. Улсын нийт гадаад өр, тэрбум ам.доллар, үлдээгдлээр /2018-2023.09.30/



Улсын нийт гадаад өрийг зээлдүүлэгч тус бүрээр харуулбал Олон зээлдүүлэгч оролцсон зээллэгийн үлдэгдэл 12.8 тэрбум ам.доллар, Нидерланд улсын 11.6 тэрбум ам.доллар, БНХАУ-ын 3.6 тэрбум ам.доллар, Япон улсын 1.2

тэрбум ам.доллар, Сингапур улсын 1.0 тэрбум ам.доллар, бусад улсын 3.8 тэрбум ам.доллартой тэнцэж байна.

График №2. Улсын нийт гадаад өр, зээлдүүлэгчээр, тэрбум ам.доллар, хувиар /2023.09.30/



Эх сурвалж: Монголбанк

2.1 Засгийн газрын өрийн өнөөгийн нөхцөл байдал

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2023 оны 3-р улирлын байдлаар 30,833.1 тэрбум төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа 44.3 хувьтай тэнцэж байна. Энэ нь 2019 оны мөн үеэс 10.8 хувиар буурсан үзүүлэлт юм.

Хүснэгт № 1. Засгийн газрын өр, 2019-2023.09.30 онд, тэрбум.төгрөг

| ӨРИЙН БҮТЭЦ, ӨРИЙН ХЭРЭГСЭЛ | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023.09.30 |
|--|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|
| 1. Засгийн газрын дотоод өр | 1,399.6 | 1,136.6 | 657.3 | 1,035.5 | 534.1 |
| 1.1. Үнэт цаас | 1,399.6 | 1,136.6 | 657.3 | 1,035.5 | 534.1 |
| 2. Засгийн газрын гадаад өр | 20,728.1 | 24,851.4 | 24,693.3 | 29,641.6 | 29,278.3 |
| 2.1. Үнэт цаас | 7,927.2 | 8,354.0 | 8,175.6 | 9,359.8 | 9,141.9 |
| 2.2. Зээл | 12,800.9 | 16,497.4 | 16,517.7 | 20,281.8 | 20,136.3 |
| 3. Бусад өр төлбөр | 2072.0 | 1,910.6 | 1,550.4 | 1,276.4 | 1,020.8 |
| 3.1. Засгийн газрын өрийн баталгаа | 1,076.3 | 1,060.4 | 876.5 | 812.9 | 728.3 |
| 3.2. Концесс ("барих-шилжүүлэх") | 995.7 | 850.2 | 673.9 | 463.5 | 292.5 |
| 4. Орон нутгийн зээллэг | - | - | 17.2 | 12.3 | - |
| ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (I+II+III) | 24,199.7 | 27,898.6 | 26,918.1 | 31,965.8 | 30,833.1 |

| | | | | | |
|---|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|
| ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР (ӨҮЦ) | 20,525.6 | 23,024.3 | 21,837.3 | 27,691.6 | 26,978.7 |
| <i>Төсвийн тогтвортой байдлын тухай тогтоосон өрийн хязгаар</i> | 75% | 70% | 70% | 70% | 65% |
| <i>Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ</i> | 55.1% | 62.3% | 50.8% | 52.4% | 44.3% |

Эх сурвалж: Сангийн яам


Засгийн газрын зүгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагын үзүүлэлтийг 2019-2023.09.30 онд бүрэн ханган ажилласан бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдалд эдийн засгийн өсөлтийг тогтвортой хадгалан арилжааны нөхцөлтэй гадаад, дотоод зээллэгийн үлдэгдэл, Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийг бууруулан Засгийн газрын гадаад өрийн хэрэгсэл (“бонд” гэх)-ийн дахин санхүүжилтийн арга хэмжээг бодит үр өгөөжтэйгөөр хэрэгжүүлсэн.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн өрийн үлдэгдлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2023 оны төсвийн жилд 65 хувиас хэтрүүлэхгүй байхаар заасан. Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2023 оны 3-р улирлын байдлаар 30.8 их наяд төгрөг, өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл 26.9 их наяд төгрөг буюу ДНБ-ий 44.3 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн тусгай шаардлагыг **бүрэн хангаж байна.**

2.1.1 Дотоод үнэт цаас

Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдэл 2023 оны 3-р улирлын байдлаар 534.1 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс 437.5 тэрбум төгрөг төсвийн алдагдал санхүүжүүлэх, 96.0 тэрбум төгрөг нь “Сайн хувьцаа” хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар арилжаалсан үнэт цаас байна. Засгийн газар 2017 оны 10 дугаар сараас хойш дотоод зах зээлд Засгийн газрын үнэт цаас арилжаалаагүй бөгөөд төлбөрийн үүргийг хуваарийн дагуу гүйцэтгэж байгаа тул дээрх хугацаанаас хойш дотоод үнэт цаасны үлдэгдэл 3 дахин буурч 2021 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 657.3 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд Засгийн газрын өрийн оновчтой багцын бүтцийг бий болгох, Засгийн газрын санхүүжилтийн хэрэгцээг бага зардлаар, боломжит эрсдэлийн түвшинд хангах зорилгоор Сангийн сайдын 2022 оны 7 дугаар сарын сарын 6-ны өдрийн 145 дугаар тушаалын дагуу 300.0 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын дотоод үнэт цаасыг “Хадгаламжийн даатгалын корпорацн сан”-д, Сангийн сайдын 2022 оны 11 дүгээр сарын сарын 29-ний өдрийн 183 дугаар тушаалын дагуу 383.9 тэрбум төгрөгтэй тэнцэх Засгийн газрын дотоод үнэт цаасыг “Монгол Улсын Хөгжлийн банк”-д хаалттай хүрээнд арилжаалсан байна.

График №3. Засгийн газрын дотоод үнэт цаас, тэрбум ₮, 2016-2023.09.30



Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор 2023 онд Засгийн газрын дотоод үнэт цаасыг Монголын Хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй арилжаалах мөн Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийг дэмжих зорилгоор Тендерийн барьцааны зориулалттай дотоод үнэт цаас гаргах, үүнтэй холбоотой журамд нэмэлт өөрчлөлт оруулах, арилжааны дэд бүтцийг сонгох зэрэг бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Засгийн газрын үнэт цаасны арилжааг Монголбанкаар дамжуулан арилжаалснаар анхдагч зах зээл дэх арилжааны банкнаас бусад оролцогчдын оролцоо хязгаарлагддаг тул шударга өрсөлдөөнт байдлаар үнэт цаасны хүү тогтох боломж дутмаг байдаг сул талуудтай байсан. Түүнчлэн, энэхүү үнэт цаасны үлдэгдлийн 90 орчим хувь нь арилжааны банкуудад ноогдож байв.

Дээрх шалтгаануудын улмаас Засгийн газрын дотоод үнэт цаасны нээлттэй арилжаа 2017 оноос эхлэн зогсож дахин арилжаа хийгдээгүй бөгөөд 2022 онд Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Өрийн удирдлагын тухай хууль, “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг үндэслэн 2022 оны 7 болон 11 саруудад нийт 683.9 тэрбум төгрөгийн үнэт цаасыг дотоодын аж ахуйн нэгжүүдэд гаргаж, 2022 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлээд байна.

Цаашид Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжааг мэргэжлийн хөрөнгө оруулагч, иргэд, аж ахуй нэгжийн оролцоог бүрэн хангах байдлаар нээх, үнэт цаасны оролцогчдын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх олон нийтэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Ингэснээр хөрөнгө оруулагчдын бааз суурь нэмэгдэж, Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах давуу талуудтай болно.

2.1.2 Гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2023 оны 3-р улирлын байдлаар 9,141.9 тэрбум төгрөг буюу 2,642.5 сая ам.доллартой тэнцэж байна. 2023 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй “Гэрэгэ” бондын үлдэгдэл төлбөрийн төлж дууссан бөгөөд 2024 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй “Хуралдай” бондын төлбөр болох 392.5 сая ам.доллартой тэнцэж байгаа бөгөөд тус бондын төлбөрийг төсвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс боломжит хэмжээгээр төлж үлдсэн хэсгийг өрийн зохицуулалтын арга хэмжээг энэ оны 11 сард хийж 350 сая ам.долларын хэмжээтэй, 5.5 жилийн хугацаатай 7.875 хувийн хүүгийн түвшинтэйгээр “Сенчири-3” бондыг гаргаад байна.

Хүснэгт № 2. Гадаад үнэт цаас, тэрбум төгрөг /2023.09.30/

| № | Гадаад үнэт цаас | Гаргасан хэмжээ /сая \$/ | Гаргасан огноо | Хүү | Хугацаа | Үлдэгдэл /тэрбум ₮/ |
|-------------|------------------|--------------------------|----------------|----------|---------|---------------------|
| 1 | Чингис-2022 | 1,000.0 | 2012/12 | 5.125% | 10 жил | - |
| 2 | Чингис-2017 | 500.0 | 2012/12 | 4.125% | 5 жил | - |
| 3 | Дим Сам | 161.2 | 2015/06 | 7.500% | 3 жил | - |
| 4 | Мазаалай | 500.0 | 2016/04 | 10.875 % | 5 жил | - |
| 5 | Хуралдай | 600.0 | 2017/03 | 8.750% | 7 жил | 1,358.1 |
| 6 | Гэрэгэ | 800.0 | 2017/10 | 5.625% | 5.5 жил | 0.0 |
| 7 | Номад | 600.0 | 2020/09 | 5.125% | 5.5 жил | 2,075.7 |
| 8 | Сенчири-2027 | 500.0 | 2021/06 | 3.500% | 6 жил | 1,729.7 |
| 9 | Сенчири-2031 | 500.0 | 2021/06 | 4.450% | 10 жил | 1,729.7 |
| 10 | Сенчири-2 | 650.0 | 2023/01 | 8.650% | 5.5 жил | 2,248.7 |
| НИЙТ | | 5,161.2 | | | | 9,141.9 |

Эх сурвалж: Сангийн яам

Засгийн газрын зүгээс стратегийн баримт бичгийн хэрэгжилтийг хангах, дунд хугацааны төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 600.0 сая ам.долларын 5.125 хувийн хүүтэй “Номад” бондыг арилжаалж 2021 онд төлөгдөх 10.875 хувийн хүүтэй “Мазаалай” бонд, 2022 онд төлөгдөх 5.125 хувийн купонтой “Чингис” бондын тодорхой хэсгийг буцаан худалдан авсан. Мазаалай бондын үлдэгдэл 132.6 сая ам.долларын үндсэн төлбөрийг улсын төсвөөс 2021 оны 4 дүгээр сард бүрэн төлж барагдуулсан. Мөн 2021 оны 7 дугаар сард “Сенчири” төслийн хүрээнд хугацаа тулаад байсан 2012 онд гаргасан “Чингис” бонд болон 2017 онд гаргасан “Гэрэгэ” бондын өр төлбөрийн тодорхой хувийг дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бөгөөд түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр буюу 6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй, 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын өр төлбөрийг

шийдвэрлэсэн бөгөөд Чингис бондын үлдэгдэл 136.8 сая ам.долларыг 2022 оны 12 дугаар сард бүрэн төлж барагдуулсан.

Түүнчлэн, Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2022-2023 онд эргэн төлөгдөх “Гэрэгэ” бондын 15.8 сая ам.доллар, “Чингис” бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.3 сая ам долларын Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаг үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгөөр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.8 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт үүсгэсэн.

Харин 2023 онд Засгийн газрын зүгээс олон улсын санхүүгийн зах зээлийн нөхцөл байдлыг анхааралтай ажиглаж, олон улсын хөрөнгө оруулагчидтай тогтмол мэдээлэл солилцож, эдийн засгийн үзүүлэлтүүд 2022 оны гүйцэтгэлээр сайжирч, зах зээлийн цонх үеийг ашиглан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр “Сенчири 2” төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар 5 жилийн хугацаатай, 8.65 хувийн хүүтэй, нийт 650 сая ам.долларын өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлж хугацаа тулаад байсан “Гэрэгэ” бондоос 149.3 сая ам.доллар, “Хуралдай” бондоос 495.3 сая ам.доллартой тэнцэх хэсгийг дахин санхүүжүүлээд байна.

2.1.3 Гадаад зээл

Засгийн газар 1991 оноос хойш нийт 366 төсөл, хөтөлбөр санхүүжүүлэх зориулалтаар 8.5 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийг авч ашигласан бөгөөд үүнээс 5.7 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг төслийн зээлд буюу 324 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд зарцуулсан бол төсвийн дэмжлэгийн зориулалтаар 2.7 тэрбум ам.доллартой тэнцэх 42 хөтөлбөрийн зээлийн хөрөнгийг авч ашигласан байдаг. Төслийн зээлийн 3.5 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг нийгмийн шинж чанартай, эргэн төлөгдөхгүй 169 төслийн зээлд, 2.2 тэрбум ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг эдийн засгийн үр өгөөжтэй, дотоодод дамжуулан зээлдүүлэх 127 төслийн зээлд зарцуулсан.

Энэ хүрээнд үүссэн гадаад зээлийн үлдэгдэл 2023 оны оны 3-р улирлын байдлаар 20,136.3 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Арилжааны нөхцөлтэй зээллэг нэмж авч ашиглаагүй бөгөөд Кредит Свисс банкны арилжааны зээлийг 2021 онд төлж барагдуулсан.

Хүснэгт № 3. Гадаад зээлийн үлдэгдэл, тэрбум төгрөг /2019-2023.09.30/

| Төрөл | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 | 2023.09.30 |
|------------------|---------|---------|---------|---------|------------|
| Хөтөлбөрийн зээл | 3,265.1 | 5,389.4 | 5,450.7 | 6,551.9 | 6,467.2 |

| | | | | | |
|----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|-----------------|
| Төслийн зээл | 9,109.3 | 10,937.0 | 11,066.9 | 13,729.9 | 13,669.1 |
| Арилжааны зээл | 426.4 | 170.9 | - | - | - |
| НИЙТ | 12,800.8 | 16,497.4 | 16,517.6 | 20,281.8 | 20,136.3 |

Засгийн газрын гадаад төслийн зээлийн ашиглалтын 46.6 хувийг дэд бүтцэд, 29.2 хувийг эргэлтийн хөрөнгөд, үлдсэн 24.1 хувийг нийгмийн чанартай төсөл хөтөлбөрүүдэд зарцуулжээ. Дэд бүтцийн салбарын 86.8 хувийг зам, тээврийн салбар, үлдсэн 13.2 хувийг уул уурхай, эрчим хүчний салбарууд тус тус эзэлж байна.

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл бодитоор жил бүр өсөж байгаа бөгөөд 2023 оны 3-р улирлын байдлаар ашиглаагүй үлдэгдэл 2.9 тэрбум ам.доллар буюу 10.4 их наяд төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс жил бүр Улсын төсөвт төсөвлөхдөө нийт гадаад зээлийн ашиглалтын хэмжээг 1.3 их наяд төгрөгөөс ихгүй байхаар хязгаарладаг тул үлдэж буй ашиглаагүй зээлийн хэмжээнд тодорхой хувиар шимтгэл төлөх нөхцөлтэй зээлд төлж байгаа зээлийн хэмжээ жилд дунджаар 10.0 тэрбум төгрөгт хүрсэн.

Түүнчлэн, гадаад зээлийн нийт авч ашигласан хөрөнгийг задалж харвал, 39.5 хувийг барилгын ажил, 26.2 хувийг тоног төхөөрөмж, 14.4 хувийг үйл ажиллагааны зардал, 12.7 хувийг зөвлөх үйлчилгээний зардалд, 5.1 хувийг магадалшгүй зардалд, үлдсэн 2.1 хувийг санхүүгийн шимтгэлд зарцуулсан байна.

Цаашид Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 стратегийн баримт бичгийн хүрээнд Засгийн газар хөгжлийн түншүүдтэй хөгжлийн хамтын ажиллагааны дунд хугацааны стратегийг тохиролцон Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан, тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эх үүсвэр баталгаажсан, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ байх шаардлагыг тавьж, үргэлжилж буй төслүүдийн хувьд тухайн жилд дуусгавар болох төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, тэргүүлэх ач холбогдолтой, амжилттай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дэмжих зарчмыг баримтлан ажиллана.

2.1.4 Засгийн газрын өрийн баталгаа

Өрийн удирдлагын тухай хууль 2015 оны 02 дугаар сард батлагдсанаар Засгийн газрын өрийн баталгаа гаргахад баталгаа гаргуулагч болон төсөл арга хэмжээнд тавигдах шаардлага хуульчлагдаж, өрийн баталгаа гаргуулах хүсэлтэд эрсдэлийн үнэлгээ хийх, төсөл арга хэмжээнд хяналт тавих зэрэг хууль эрх зүйн орчин бүрдсэн. Тус хууль батлагдахаас өмнө Засгийн газрын зүгээс Монгол Улсын Хөгжлийн банкны дунд хугацааны евро бонд, Самурай бонд, Кредит Свисс банкнаас авсан зээл, БНХАУ-ын Хөгжлийн банкнаас авсан зээл, "МИАТ" ТӨХК-ийн агаарын хөлгийн санхүүжилт зэрэг нийтдээ 2.7 их наяд төгрөгтэй тэнцэх зээллэгүүдэд баталгааг гаргасан байдаг.

Энэхүү шаардлагад баталгаа гаргуулагч байгууллага нь сүүлийн 3 жил ашигтай ажилласан, хугацаа хэтэрсэн өргүй, зээлдүүлэгч байгууллагатай нэгдмэл сонирхолгүй, хэрэгжүүлж буй төслийн бэлтгэл ажил хангагдсан буюу техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ хийгдсэн байх, холбогдох мэдээлэл, тайлан тооцоо, баримт бичгийг бүрдүүлсэн, зээллэгийн хөрөнгийг эргэн төлөх чадвартай байх зэрэг шаардлагуудыг хангахаар тусгагдсан. Ингэснээр Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах, төсөвт учирч буй болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах хөшүүрэг болж өгсөн. Өрийн удирдлагын тухай хууль батлагдсанаас хойш Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээлд арилжаалсан үнэт цаас, “Эрдэнэс Монгол” ХК-ийн АХБ-аас авсан зээлүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан.

Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2023 оны 3-р улирлын байдлаар 728.3 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Үүнээс Монгол Улсын Хөгжлийн банкны баталгааны үлдэгдэл 696.9 тэрбум төгрөг, “Эрдэнэс Монгол” ХК-ийн баталгааны үлдэгдэл 31.4 тэрбум төгрөг байна.

Хүснэгт № 4. Засгийн газрын баталгаа /2023.09.30/

| № | Баталгаа гаргуулагч | Зээлдүүлэгч | Валют | 2023.09.30 | |
|-------------|----------------------------|--------------------------|-----------|--------------------|---------------|
| | | | | Үндсэн валют /сая/ | Тэрбум төгрөг |
| 1 | Монгол Улсын Хөгжлийн банк | Японы хөрөнгө оруулагчид | Иен | 30,000.0 | 696.9 |
| 2 | Эрдэнэс Монгол ХХК | Азийн хөгжлийн банк | Ам.доллар | 9.1 | 31.4 |
| НИИТ | | | | | 728.3 |


Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдлийн 95.7 хувийг эзэлж байгаа Монгол Улсын хөгжлийн банкны 30.0 тэрбум иенийн “Самурай” бондын төлбөрийг 2023 онд төлөх хуваарьтай бол Эрдэнэс Монгол ХК-ийн техникийн туслалцааны зээлийг 2031 онд тус тус төлөх хуваарьтай.

2.1.5 “Барих-шилжүүлэх” төрлийн концесс

Улсын төсвөөс 2014-2017 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 2.3 их наяд төгрөгтэй тэнцэх 40 концессын гэрээ болон орон нутгийн төсвөөс 2013-2016 онд эргэн төлөгдөх нөхцөлтэй 133.4 тэрбум төгрөгтэй тэнцэх 50 концессын гэрээ тус тус байгуулагдсан байна. “Барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ байгуулагдсан дүнгээр Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдэж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг өсгөж, ирэх онуудын төсөвт ирэх төлбөрийн дарамт эрс нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолоор барих-шилжүүлэх концессын гэрээг дахиж байгуулахгүй байх, гэрээ нь хүчин төгөлдөр болоогүй төсөл арга хэмжээг зогсоох шийдвэр гарсан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсэгт улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээ нь өрийн хэрэгсэлд тооцогдохоор хуульчлагдсан бөгөөд мөн хуулийн 40.7 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг хүчин төгөлдөр болсон өдрөөр өрийн мэдээллийн нэгдсэн санд оруулж, концессын гэрээний дагуу улирал бүр гарсан ашиглалтыг үндэслэж Засгийн газрын өрд бүртгэнэ” гэж заасан. Сангийн яам Концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Үндэсний хөгжлийн газар) болон орон нутгийн захиргааны байгууллагуудаас улирал бүр ашиглалт, гүйцэтгэлийн мэдээллийг авч Засгийн газрын өрд бүртгэж байна.

График № 4. Барих-шилжүүлэх төрлийн концессын үлдэгдэл, 2023.09.30, тэрбум ₮



Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөх концессын үлдэгдэл 2023 оны 3-р улирлын байдлаар 292.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

2.1.6 Улсын секторын өр

Улсын секторын өр нь Засгийн газрын өрөөс гадна Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдүүдийн өр төлбөрийг нэгтгэж тооцсон ойлголт бөгөөд Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагаас дэлхийн улс орнуудын улсын өрийн статистикийг тогтсон стандартын дагуу нэгтгэн улирал бүр тайлан гаргадаг байна. Тус статистикийг гаргаснаар Засгийн газар ирээдүйд гарч болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, оновчтой удирдах хөшүүргийг бие болгох онцлог ач холбогдолтойгоос гадна мэдээллийн ил тод байдлыг сайжруулж байдаг байна.

Хүснэгт № 6 Монгол улсын секторын өрийн статистик 2022-2023.06.30 т.б ₮

| | 2022.06.30 | 2022.12.31 | 2023.06.30 |
|--|-----------------|-----------------|-----------------|
| I. Засгийн газрын өр | 28,508.8 | 31,964.8 | 31,105.4 |
| Төв Засгийн газрын өр | 27,076.7 | 30,677.1 | 30,018.4 |
| Орон нутгийн өр | 21.0 | 12.3 | - |
| Засгийн газрын баталгаа | 940.7 | 811.8 | 744.1 |
| Барих-Шилжүүлэх концессын үлдэгдэл | 470.5 | 463.5 | 342.8 |
| III. Төрийн өмч, төрийн өмч давамгайлсан санхүүгийн бус салбарын байгууллагуудын өр | 6,803.5 | 7,959.8 | 8,048.9 |
| Үүнээс: | | | |
| Гадаад | 5,049.9 | 4,415.5 | 3,779.7 |
| Богино хугацаат өр | 2,779.9 | 3,684.5 | 3,327.3 |
| Урт хугацаат өр | 2,270.0 | 731.0 | 452.3 |
| Дотоод | 1,753.5 | 3,544.3 | 4,269.2 |
| Богино хугацаат өр | 601.5 | 1,566.5 | 1,684.4 |
| Урт хугацаат өр | 1,152.0 | 1,977.8 | 2,254.8 |
| Улсын секторын өр (I+II+III) | 35,312.3 | 39,924.6 | 39,154.3 |

Дээрх хүснэгтэд улсын секторын өрийн статистикийг нэгтгэн харуулсан ба Төрийн өмч, төрийн өмч давамгайлсан санхүүгийн бус салбарын байгууллагуудын хамгийн том буюу нийт өрийн 90 -ээс дээш хувийг эзэлж буй 15 байгууллагыг багтаасан. Тус статистик аргачлалыг гаргахдаа ОУВС-аас 2011 оноос хойш гаргаж буй Public Sector Debt Statistics Guide-д заасны дагуу санхүүгийн бус төрийн өмчит хуулийн этгээдийн өр болон Засгийн газрын өрийг багтааж тооцсон болно.

Улсын хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлага нь төрийн салбарт тулгарч болох санхүүгийн эрсдэлүүдийг тодорхойлж, урьдчилан сэргийлснээр санхүүгийн тогтвортой байдлыг хадгалж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оршино. Засгийн газрын тайлан тэнцэл нь хөрөнгө, өр төлбөрөөс бүрдэх бөгөөд улс улсын онцлогоос хамаарч Төв засгийн газар, орон нутгийн захиргаа, тэтгэврийн сан, төрийн өмчит компани, Төв банкныг хамруулдаг. Улсын хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлагыг оновчтой хэрэгжүүлснээр ханш, хүү, инфляц, түүхий эдийн ханш зэрэг хүчин зүйлийн эрсдэлээс сэргийлээд зогсохгүй нийгмийн халамж гэх мэт эх үүсвэр нь

тодорхойгүй, ирээдүйд гарах төсвийн зардал зэрэг урт хугацааны төсвийн асуудлуудыг ч шийдэх боломж бүрддэг.

Гэвч ихэнх улс орны жишээнээс харахад хөрөнгө, өр төлбөрийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд хэд хэдэн нийтлэг бэрхшээл тулгардаг. Нэгт, улс орнуудын нэгтгэсэн тайлан тэнцэлд тухайн улсын нийт хөрөнгө бүртгэгдсэн байх нь ховор бөгөөд энэ нь бүх хөрөнгө болон өр төлбөрийн мэдээллийг шууд авахад хүндрэл учруулдаг. Засгийн газрын түгээмэл тайлан тэнцлийн хөрөнгө талд зам, дэд бүтэц зэрэг үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчит компаниудын хөрөнгө зэрэг хөдлөх хөрөнгө байдаг. Хэдийгээр төв банк хараат бус үйл ажиллагаатай ч ихэнх улсад Засгийн газрын ашиг алдагдлыг зохицуулах зорилгоор арилжаа гүйлгээ хийдэг тул Засгийн газрын тайлан тэнцэлд багтдаг. Засгийн газрын хөрөнгө дотор томоохон хувийг ирээдүйн төсвийн орлого эзэлдэг бол өр төлбөр талд ч мөн ихээхэн хувийг ирээдүйн төсвийн зардал эзэлдэг.

| ХӨРӨНГӨ | ӨР ТӨЛБӨР |
|---|--|
| Үл хөдлөх хөрөнгө (газар, дэд бүтэц) | Засгийн газрын өр |
| Төрийн сангууд | Төслийн гүйцэтгэгчдэд шилжүүлэх төлбөрүүд |
| Төрийн өмчит компаниудын хөрөнгө | Гэрээгээр шилжүүлэх бусад шилжүүлэг |
| Төв банкин дахь гадаад валютын нөөц | Ирээдүйн төсвийн зардлын өнөөгийн үнэ цэнэ |
| Бусад санхүүгийн хөрөнгө | |
| Ирээдүйн төсвийн орлогын өнөөгийн үнэ цэн | |

2.1.7 Орон нутгийн өр

Өрийн удирдлагын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтад тусгасны дагуу аймаг, нийслэлийн өрийг Засгийн газрын өрд бүртгэж, тайлагнадаг. Энэ хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс 2021 онд Монгол Улсын Хөгжлийн банкнаас нийтийн тээврийн авто баазыг нэмэгдүүлэх зорилгоор авч ашигласан 21.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг Засгийн газрын өрд бүртгэсэн бөгөөд 2023 онд дууссан байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын зүгээс Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулж, түгжрэлийг бууруулах, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөх, агаарын бохирдлыг бууруулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор 500 тэрбум төгрөг хүртэлх хэмжээний үнэт цаасыг дотоодын зах зээлд

арилжаалах төлөвлөгөөтэй байгаа бөгөөд эхний ээлжид 2023 онд багтаан Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, инженерийн дэд бүтцийн хүртээмж, авто зам, замын байгууламжийн сүлжээг нэмэгдүүлэх, сургууль цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Түүнчлэн, 2024 онд Сэлбэ, дунд голын дагуу үерийн гамшгаас сэргийлж, далан байгуулах, Улаанбаатар хотын авто замын сүлжээний нэвтрүүлэх чадварыг сайжруулж, түгжрэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй “Сэлбэ сэргэлт” төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд үе шаттайгаар бондыг арилжаалахаар байна.

Орон нутгийн Засаг даргын Тамгын газруудыг дотоодын зах зээлд үнэт цаас гаргах асуудал нь одоогийн байдлаар эрх зүйн орчин дутмаг, бусад арилжаанд оролцогч байгууллагуудтай харилцах харилцааны асуудал тодорхой бус байна. Энэ асуудлыг шийдвэрлэхээр Засгийн газрын зүгээс ажиллаж байгаа бөгөөд тодорхой төсөл, арга хэмжээг улсын төсөв, гадаад зээлээс санхүүжүүлэхээс гадна орон нутгийн төсөвт үнэт цаас гаргах замаар хэрэгжүүлэх нь ихээхэн боломжийг нээж өгөхөөр байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2019-
2022 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ БҮТЭЦ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

1. Дунд хугацааны зорилтуудын хүрээнд авч хэрэгжүүлсэн өрийн удирдлагын арга хэмжээ

“Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т дунд хугацаанд өрийн удирдлагын хүрээнд 5 зорилтыг дэвшүүлсэн бөгөөд зорилт тус бүрийн хүрээнд 2019, 2020, 2021 болон 2022 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

Зорилт 1. Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

1.1 Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай үргэлжлүүлэх замаар төсвийн алдагдал болон шинээр зээллэг үүсгэх хэрэгцээг бууруулна.

Зорилтын хүрээнд төсвийн алдагдлыг бууруулж, өрийн хэрэгслийг хязгаарлах замаар шинээр өр үүсгэх шаардлагыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэхээр Стратегийн баримт бичигт тусгасан. Төсвийн сахилга бат, санхүү мөнгөн хөрөнгийн удирдлагыг сайжруулах бодлогыг тууштай хэрэгжүүлэх ажлын хүрээнд Сангийн яамнаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баталж төсвийн алдагдал болон шинээр үүсгэх зээлийн хэрэгцээг бууруулсан.

Хүснэгт № 1 Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2019-2022 т.б ₮

| Он | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|------------|-------------|-------------|-------------|-------------|
| Төлөвлөгөө | 2,375.0 | 5,252.7 | 4,001.2 | 2,387.1 |
| Гүйцэтгэл | 711.8 | 4,440.4 | 2,908.8 | 1,124.6 |
| Зөрүү | 1,663.2 | 812.3 | 1,092.4 | 1,262.5 |

Энэ нь жил бүр төлөвлөсөн дүнгээс төсвийн алдагдал бага гарсан үзүүлэлтүүд байгаа бөгөөд энэхүү дүнгээр шинээр үүсгэх байсан өрийн хэмжээ буурсан байна.

1.2 Өрийн удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан өрийн багцын оновчтой бүтцийг бий болгох зохицуулалтын арга хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай, бие даан авч хэрэгжүүлнэ.

Сангийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 157 дугаар тушаалаар Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн Зорилт 1-т заасан Өрийн удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан өрийн багцын оновчтой бүтцийг бий болгох зохицуулалтын арга хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр шуурхай, бие даан авч хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын гадаад үнэт цаас гаргах боломжийг судлан, санал боловсруулах, зуучлагч банк, санхүүгийн байгууллага болон холбогдох талуудтай харилцах, хөрөнгө оруулагчидтай хийх уулзалт, шаардлагатай бусад бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлыг хэсгийг байгуулан Өрийн зохицуулалтыг “Номад” болон “Сенчири” төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

1.3 дахь арга хэмжээ: Гадаад зах зээлийн нөхцөл байдал, зардал, эрсдэлийн судалгааг тогтмол хийж, гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авсан.

Монгол Улсын Засгийн газар нь ирэх жилүүдэд төлөх Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх ачааллыг урт хугацаанд тараан жигдлэх, өрийн багцын эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгах, эдийн засаг, санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Засгийн газрын 2019-2022 оны өрийн стратегид нийцүүлэн хугацаа нь тулаад байсан 10 жилийн хугацаатай, 1 тэрбум ам.долларын “Чингис бонд”, 800 сая ам.долларын “Гэрэгэ” бонд, 600 сая ам.долларын Мазаалай бондуудын өр төлбөрүүдийг дахин санхүүжилт хийж өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Чингис, Мазаалай бондыг буцаан худалдан авах саналыг 2020 оны 9 дүгээр сарын 21-ээс 9 дүгээр сарын 25-ны өдрүүдэд хүлээн авч, 600 сая ам.долларын 5.5 жилийн хугацаатай “Номад” бондыг 2020 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр, 5.125 хувийн хүүтэйгээр олон улсын зах зээл дээр арилжаалсан. Уг бонд нь өрийн зохицуулалтын хүрээнд арилжаалсан Засгийн газрын гурав дахь гадаад бонд бөгөөд богино хугацаанд зах зээлийн хамгийн тохиромжтой нөхцөлд бага хүүтэйгээр арилжаалснаараа онцлог юм. “Сенчири” төслийн хүрээнд түүхэндээ хамгийн бага түвшний хүүтэйгээр буюу 6 жилийн хугацаатай 3.5 хувийн хүүтэй 500 сая ам.доллар, 10 жилийн хугацаатай 4.45 хувийн хүүтэй, 500 сая ам.доллар, нийт 1.0 тэрбум ам.долларын өрийн зохицуулалтыг амжилттайгаар авч хэрэгжүүлсэн бөгөөд Азийн зах зээл дээр шилдэг арилжаагаар нэрлэгдэж, Finance Asia сэтгүүлийн “Оны шилдэг Засгийн газрын бонд”, “Оны шилдэг хөгжиж буй зах зээлийн арилжаа” шагналуудыг авсан.

Өрийн удирдлагын тухай хуулийн 26.10-д заасны дагуу өрийн зохицуулалттай холбоотой “Засгийн газрын гадаад үнэт цаасыг гаргах, арилжаалах журам”-ыг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 17-ны 65 дугаар тогтоолоор баталсан. Тус журам батлагдсанаар олон улсын зах зээлд Засгийн газрын гадаад

үнэт цаас (ЗГГҮЦ) гаргах, арилжаалахтай холбоотой бэлтгэл ажлыг хангах, ЗГГҮЦ гаргахад үйлчилгээ үзүүлэх талуудыг сонгон шалгаруулах үйл ажиллагаа, арилжаа зохион байгуулах, бүртгэх, тайлагнах, хөрөнгө оруулагчидтай харилцахтай холбоотой харилцааг зохицуулах бөгөөд Засгийн газрын гадаад үнэт цаас арилжаалах үйл явц ил тод, боловсронгуй зохион байгуулагдах нөхцөл боломжийг олгосон юм.

2022 оны 10 дугаар сард “Блүүмберг” олон улсын мэдээллийн платформд гарсан мэдээнээс шалтгаалж Монгол Улсын Засгийн газраас арилжаалсан бондын үнэ анх гаргасан үнээс буурсан үеийг ашиглаж хоёрдогч зах зээлээс нийт 15.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний бондыг буцаан худалдан авч 0.8 сая ам.доллартой тэнцэх хэмжээний ашигтай ажилласан байна.

Түүнчлэн, Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2022-2023 онд эргэн төлөгдөх “Гэрэгэ” бондын 15.8 сая ам.доллар, “Чингис” бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.3 сая ам долларын Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаг үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгөөр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний зардлаас нийт 1.8 тэрбум төгрөгийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт гаргасан.

1.4 Дахин санхүүжилт хийхээс өөрөөр арилжааны нөхцөлтэй гадаад үнэт цаас гаргахаас татгалзаж, өрийн дахин санхүүжилтэд урт хугацаанд жигд төлөгдөх эх үүсвэр ашиглахыг эрмэлзэнэ.

Засгийн газрын зүгээс олон улсын байгууллага, нэг болон олон талт түнш, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагч хувийн аж ахуйн нэгж зэрэг зээлдүүлэгч талуудтай байгуулсан гэрээний хуваарийн дагуу 2019 онд 1,464.4 тэрбум төгрөг, 2020 онд 1,886.8 тэрбум төгрөг, 2021 онд 2,389.6 тэрбум төгрөг, 2022 онд 2,210.9 тэрбум төгрөгийг шинээр арилжааны нөхцөлтэй зээл авахгүйгээр улсын төсвөөс төлж барагдуулсан.

Хүснэгт № 1. Засгийн газрын өрийн үйлчилгээ 2019-2021, тэрбум төгрөг

| Өрийн үйлчилгээ | 2019 | 2020 | 2021 | 2022 | Нийт |
|------------------------|----------------|----------------|----------------|----------------|----------------|
| Үндсэн төлбөр | 603.4 | 954.0 | 1,590.0 | 1,419.1 | 4,566.5 |
| Гадаад үнэт цаас | | | 377.8 | 521.4 | 899.2 |
| Гадаад зээл | 438.3 | 691.0 | 732.8 | 592.0 | 2,454.1 |
| Дотоод үнэт цаас | 165.1 | 263.0 | 479.3 | 305.7 | 1,213.1 |
| Хүүгийн төлбөр | 861.0 | 932.8 | 799.6 | 791.8 | 3,385.2 |
| Гадаад үнэт цаас | 507.7 | 577.8 | 468.1 | 496.5 | 2,050.1 |
| Гадаад зээл | 167.5 | 197.9 | 212.9 | 181.0 | 759.3 |
| Дотоод үнэт цаас | 185.8 | 157.1 | 118.6 | 114.3 | 575.8 |
| Нийт | 1,464.4 | 1,886.8 | 2,389.6 | 2,210.9 | 7,951.7 |

1.5 Засгийн газрын өрийн багц дахь хувьсах хүүтэй гадаад зээлийг зардал, эрсдэлийн судалгаагаар ашигтай нөхцөлд тогтмол хүүтэй зээлд шилжүүлнэ.

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд төсвийн алдагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг тогтмол хүүтэй зээлээр түлхүү санхүүжүүлэх, цаашлаад Лондонгийн банк хоорондын хүү /ЛИБОР/ хэрэглэгдэхээ больж байгаатай холбогдуулан зарим хувьсах хүүтэй өрийг тогтмол хүүтэй болгох төлөвлөгөөтэй байна. Үүнтэй холбоотойгоор тус арга хэмжээний хүрээнд Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу Засгийн газарт хувьсах хүүтэй зээлүүдийг шаардлагатай бол тогтмол хүүтэй болгох тухай асуудлыг Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 62 дугаар тогтоолыг батлуулсан.

1.6 дэх арга хэмжээ: Монгол Улсын зээлжих зэрэглэлийг хэвээр хадгалах, сайжруулах үүднээс олон улсын зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчидтай хамтран ажилласан.

Сангийн яам олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Стандарт энд Пүүрс агентлагтай 1999 оноос, Фитч Рэйтингс болон Мүүдис агентлагтай 2005 оноос Монгол Улсын зээлжих зэрэглэлийг тогтоолгох чиглэлээр тус тус хамтран ажиллаж эхэлсэн байдаг.

Улсын зээлжих зэрэглэл нь тухайн улс гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, зээлийн төлбөрөө ирээдүйд эргэн төлөх чадвар, эрсдэлийг илтгэдэг үзүүлэлт юм. Эдгээр агентлагууд улсын зээлжих зэрэглэлийг өөрсдийн тогтсон аргачлалын дагуу улсын эдийн засгийн өсөлт, төлөв байдлаас гадна төсвийн сахилга бат, өрийн удирдлага, санхүүгийн болон эдийн засгийн голлох үзүүлэлтүүд, хөрөнгө оруулалт, гадаад секторын нөхцөл байдал, улс төр, нийгэм болон засаглалын орчин зэрэг хүчин зүйлсэд үндэслэн тогтоодог. Мөн улсын зээлжих зэрэглэл нь тухайн улс орны аж ахуйн нэгжүүд, санхүүгийн байгууллагуудын зээлжих зэрэглэлийн жишиг үнэлгээ болж өгдөг.

Монгол Улсын хувьд олон улсын санхүүгийн зах зээлд идэвхтэй оролцож хөрөнгө босгох, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд зээлжих зэрэглэлийн үнэлгээ чухал үүрэг гүйцэтгэж байна.

Гадаад валютын албан нөөц нэмэгдэх, төсвийн алдагдал, цаашлаад Засгийн газрын өр буурах, өрийн удирдлагын зохистой бодлогыг хэрэгжүүлэх замаар өрийн дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, гадаад өрийн хэмжээг тогтвортой хэмжээнд барих, эдийн засгийн өсөлт болон экспортыг тогтвортой байлгах зэрэг нь Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахад гол нөлөөг үзүүлдэг. Харин зээлжих зэрэглэл буурахад дээрх хүчин зүйлсээс гадна Монгол Улсын төсвийн сахилга бат алдагдах, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн томоохон

төслүүд зогсох, нийгмийн болон улс төрийн тогтворгүй байдал зэрэг нь давхар сөргөөр нөлөөлж байдаг.

Монгол Улсын Сангийн яам 2019-2020 онуудад Фитч, Мүүдиз, Стандарт энд Пүүрс агентлагууд болон хөрөнгө оруулагчдад хагас жил тутам Монгол Улсын төсөв, санхүү, өрийн статистик мэдээллийг хүргүүлдэг бөгөөд Засгийн газрын бодлого, улс төр, нийгэм, засаглалын томоохон өөрчлөлтүүдийг тухай бүр мэдээлж ажилладаг. Харин зээлжих зэрэглэлийн үнэлгээг хийхэд Сангийн яам, Монголбанкнаас гадна Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, ОУВС, Дэлхийн банк, Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг хөдөлгөгч томоохон аж ахуйн нэгжүүд, хараат бус эдийн засагч зэрэг олон талын байгууллага, хувь хүнтэй уулзалтуудыг зохион байгуулж, шаардлагатай мэдээллийг хүргэж байна. Стандарт энд Пүүрс болон Фитч агентлаг 2018 оноос хойш МУ-ын зээлжих зэрэглэлийг “В, тогтвортой” гэж үнэлснээс хойш жил бүр үнэлгээ хийж тогтвортой хэвээр хадгалж ирсэн. Харин Мүүдиз агентлаг зээлжих зэрэглэлийг 2020 онд “В3, сөрөг” төлөв рүү оруулаад байсан ч 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдөр төлөвийг эргүүлэн “тогтвортой” гэж үнэлсэн байна.

Стандарт энд Пүүрс /S&P/ зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас Монгол Улсын 2022 оны зээлжих зэрэглэлийг “В, тогтвортой” хэвээр үлдээж байгаагаа 2022.07.21-ны өдөр, Фитч зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас зээлжих зэрэглэлийг мөн “В, тогтвортой” хэвээр үлдээж байгааг 2022.05.15-ны өдөр тус тус мэдэгдсэн.

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг хэвээр үлдээхэд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- БНХАУ-ын хилийн боомтын хязгаарлалтын улмаас Монгол Улсын эдийн засаг 2022 онд 2.5%-иар өсөх магадлалтай байна;
- Хилийн боомтын асуудал шийдэгдэж, уул уурхайн түүхий эдийн экспорт хэвийн гарч эхэлснээр ирэх онд эдийн засгийн өсөлт 6%-д хүрнэ гэж таамаглаж байна;
- Ковид-19 цар тахлын дараах Монгол Улсын эдийн засгийн сэргэж байгаа бөгөөд 2022 оноос төсөв, санхүү, өр нөхцөл байдал болон гадаад орчин мөн сайжрах төлөвтэй байна.

1. Эдийн засаг, засаглалын байдал:

- БНХАУ-ын хилийн боомтын асуудлаас үүдэн экспорт тасалдсанаас Ковидын дараах эдийн засгийн сэргэлт удаан байгаа хэдий ч хилийн боомтын асуудал шийдэгдмэгц дунд хугацаандаа эдийн засаг сайжрах төлөвтэй байна.
- Ирэх 2-3 жилийн эдийн засгийн төлөв эерэг хэвээр байгаа бөгөөд уул уурхайн салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт эрчимтэй нэмэгдэх хандлагатай байна.

- Улс төрийн тогтвортой байдал үргэлжилснээр бодлогын тогтвортой байдал хадгалагдах төлөвтэй байна.
2. Төсөв, санхүүгийн гүйцэтгэл:
- Монгол Улсын төсвийн үзүүлэлтүүд 2022 онд бага зэрэг муудах боловч дунд хугацааны төсвийн хүрээнд заасны дагуу алдагдлаа аажмаар сайжруулах төлөвтэй байна.
 - Монгол Улсын гадаад өр 2021 онд сайжирсан ба уул уурхайн экспорт нэмэгдэхийн хэрээр гадаад салбарын үзүүлэлтүүд ирэх 4 жилд сайжрах төлөвтэй байна.
 - МУЗГ тогтвортойгоор хөнгөлөлттэй нөхцөлтэй санхүүжилт авах боломжтой байгаа нь улсын болон гадаад өрийн түвшин нэмэгдсэнтэй холбогдох зээлийн эрсдэлийг бууруулж байна.

Монгол Улсын зээлжих зэрэглэл буурах эрсдэлд дараах хүчин зүйлсийг онцоллоо. Үүнд: "1. Гадаад санхүүжилтийн эх үүсвэр татах чадвар буурах, ГВАН нь БНХАУ-ын хилийн боомтын асуудлаас үүдэн буурах үзэгдэл ажиглагдсан зэргээс үүдэн гадаад нөхцөл байдлын эрсдэл нэмэгдэх 2. Төсвийн алдагдлыг бууруулах, Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх харьцааг тогтворжуулж чадахгүй байх 3. Улс төрийн тогтворгүй байдал нь ГШХО-ыг бууруулах, стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн төслүүдийг зогсоох эрсдэлтэй байна" гэж тус тус үзсэн .

Түүнчлэн, Монгол Улсын зээлжих зэрэглэлийг нэмэгдүүлэхэд дараах хүчин зүйлс дангаараа эсхүл хамтдаа нөлөөлөх боломжтойг онцоллоо. Үүнд: 1. ГВАН-ийг их хэмжээгээр нэмэгдүүлэх, өрийн удирдлагын стратегийн хэрэгжилтийг хангаснаар дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах, гадаад өр төлбөрийг тогтворжуулах ач холбогдолтой 2. Эдийн засгийн өсөлт хурдацтайгаар нэмэгдэх, экспортын чиг хандлага нь ямар нэгэн тасалдалгүйгээр сайжрах, ГШХО-ыг дэмжих бизнесийн таатай орчныг бүрдүүлэх 3. Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг бууруулахтай зэрэгцэн төсвийн алдагдлыг бууруулах зэрэг багтаж байна.

Зорилт 2. Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримтлан тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.

2.1 дэх арга хэмжээ: Төсвийн алдагдлыг бууруулж, өрийн хэрэгслийг хязгаарлах замаар шинээр өр үүсгэх шаардлагыг багасгасан.

Зорилтын хүрээнд төсвийн алдагдлыг бууруулж, өрийн хэрэгслийг хязгаарлах замаар шинээр өр үүсгэх шаардлагыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэхээр Стратегийн баримт бичигт тусгасан. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар нэгдсэн төсөв 4,001.2 тэрбум төгрөгийн алдагдалтай батлагдсанаас жилийн эцсийн гүйцэтгэлээр 2,908.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан бол 2022 оны нэгдсэн төсөв 2,387.1 тэрбум төгрөгийн алдагдалтай батлагдсанаас жилийн эцсийн гүйцэтгэлээр 1,124.6 тэрбум төгрөгтэй тэнцэж байна. Энэхүү үзүүлэлт нь тухайн жилд шинээр үүсгэх байсан өрийн хэмжээг бууруулж байна.

2.2 дахь арга хэмжээ: Гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийг эрэмбэлж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталсан.

Засгийн газрын зүгээс хөгжлийн стратеги, бодлого, зорилт, тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөгжлийн түншүүдтэй хөгжлийн хамтын ажиллагааны дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэн Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлээр нийгэм, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зарчмыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын 2019-2021 оны төсөвт гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын эх үүсвэрийг ОУВС-тай хамтран хэрэгжүүлсэн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-өөр тохирсон төсвийн алдагдлын хэмжээг харгалзан, зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан, тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эх үүсвэр баталгаажсан, нийгэм, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ байх, үргэлжилж буй төслүүдийн хувьд тухайн жилд дуусгавар болох төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, тэргүүлэх ач холбогдолтой болон үр ашигтай, амжилттай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дэмжих зарчим баримтлан төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Гадаад зээлийн хөрөнгөөр 2019 онд 70 төсөл хэрэгжиж 1,215.5 тэрбум төгрөг, 2020 онд 87 төсөл хэрэгжиж 1,296.6 тэрбум төгрөг, 2021 онд 80 төсөл хэрэгжиж 1,391.4 тэрбум төгрөг, 2022 онд 87 төслийн 1,712.0 тэрбум төгрөгийн ашиглалт тус тус гарсан.

Мөн Сангийн яамнаас Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж байгаа “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Монгол Улсын Засгийн газрын гадаад зээл, тусламжийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сан”-ийн цахим систем (www.odamis.mof.gov.mn)-ийг 2019 оны 8 дугаар сараас шинэчлэн боловсруулж, 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдөр үйл ажиллагааг эхлүүлж, нэвтрүүлээд байна. Энэхүү цахим системд гадаад зээлийн төсөл, арга хэмжээг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүжилтийн эрх нээх, нэгдсэн бүртгэл хөтлөх, хэрэгжилтийн явцад хяналт тавих, үнэлэх, тайлагнах бөгөөд цахим системийг шинэчлэн хэрэгжүүлснээр гадаад зээлийн төсөл, арга хэмжээний удирдлага, зохицуулалт сайжруулах, санхүүжилтийн үйл ажиллагааг шуурхай шийдвэрлэх, хяналтыг өндөржүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангах, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Мөн Засгийн газраас авч хэрэгжүүлсэн алхмууд нь төрийн үйлчилгээг цахим болгох, онлайн хэлбэрт шилжүүлэхэд чухал арга хэмжээ болсон.

Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтийг бүрэн хангах, эх үүсвэрийг үр ашигтай ашиглах, төслүүдийн санхүүжилтийг уян хатан, шуурхай шийдвэрлэх зорилгоор 2019 оноос эхлэн гадаад зээл, тусламжийн санхүүжилт болон гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын Засгийн газрын хариуцах санхүүжилтийн зардлыг Сангийн сайдын багцад тусгаж,

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан. Үүний үр дүнд амжилттай хэрэгжиж буй төслийн төсөвт тусгасан зардлын хязгаартаа хүрснээр санхүүжилт гаргах боломжгүй болдог хүндрэл арилж төслийн хэрэгжилт, гүйцэтгэл сайжирч төслүүдийн ашиглалт нэмэгдсэн.

Түүнчлэн Засгийн газрын өрийн баталгаа болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн өр төлбөрөөс үүдэлтэй Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах механизмыг бүрдүүлж, дамжуулан зээлдүүлсэн зээлийн хугацаа хэтэрсэн өр үүсэхээс сэргийлэх зорилгоор Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 233 дугаар тушаалаар “Эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ыг баталсан.

Ийнхүү Засгийн газрын гадаад зээлийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгосноор гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийг улс орны хөгжлийн стратеги, бодлого, зорилт, тэргүүлэх чиглэлтэй илүү нийцүүлэх, гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг тодорхой болгох, зээлийн хөрөнгийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт сайжирч, оролцогч талуудын үүрэг, хариуцлага нэмэгдэн, ил тод байдлыг хангаж гадаад зээлийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж илүү бүрдэж байна.

Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг төлөвлөх болон хэрэгжүүлэхдээ Улсын Их Хурлаас баталсан дараах бодлого, хөтөлбөрийг баримтлан ажиллаж байна. Үүнд:

1. Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”;
2. Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай”;
3. Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”;
4. Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Эрчим хүчний эх үүсвэр, дамжуулах, түгээх шугам сүлжээг шинээр барьж байгуулан хүчин чадлыг өргөтгөн нэмэгдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлнэ” гэж; Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 4.2.35-д Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийн босоо

болон хөндлөн гол тэнхлэгийн ЦДАШ барьж дэвшилтэт технологид суурилсан дэд бүтэц бүхий ухаалаг нэгдсэн систем байгуулна.” гэж тусгасны дагуу Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр “Чойр-Сайншандын 220 кВ-ын 2 хэлхээт 220.04 км урт ЦДАШ, дэд станц барих төсөл”-ийг хэрэгжүүлсэн.

Түүнчлэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “4.1.Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн чанар, стандартыг сайжруулан багтаамж ихтэй шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлж, гол ба үндсэн авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчилж, олон түвшний уулзварыг байгуулан хүртээмжийг нэмэгдүүлж, авто замын түгжрэлийг бууруулна.” гэж тусгасны дагуу Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийт 4 нүхэн гарц барихаар “Улаанбаатар хотод төмөр зам доогуур авто замын нүхэн гарц шинээр барих төсөл”-ийг хэрэгжүүлсэн.

2.3 дахь арга хэмжээ: Шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн саналд дүн, шинжилгээ хийх механизмыг бий болгож, эдийн засаг, нийгэмд зайлшгүй шаардлагатай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ.

Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 211 дугаар тогтоолоор баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх журам” болон Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг шинэчлэн Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар батлуулан, захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлийн 5018 дугаарт бүртгүүлэн, мөрдүүлж эхлээд байна.

Тус журмуудын өөрчлөлтөөр төсөл, арга хэмжээний хэрэгжилт худалдан авах ажиллагааны процесс буюу аливаа ажлыг гүйцэтгэгч, нийлүүлэгч, зөвлөх компанийг сонгон шалгаруулахад ихээхэн цаг хугацаа алдсаны улмаас хойшлогддог тул уг нөхцөл байдлыг арилгах, шийдвэрлэх зорилгоор төсөл, арга хэмжээ хэрэгжиж эхэлснээс хойш 1 жилийн хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж чадаагүй бол уг төсөл, арга хэмжээг зогсоох зохицуулалтыг тусгасан. Мөн төсөл, арга хэмжээний хэрэгжилт дуусахаас 6 сарын өмнө худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан нэмэлт худалдан авалт зохион байгуулахыг хориглох замаар төсөл арга, хэмжээг цаг хугацаанд нь дуусгавар болгох, уг нэмэлт худалдан авах ажиллагаатай холбогдон үр ашиггүй урсгал зардал гаргахгүй байх гэх зэрэг заалтуудаас гадна дамжуулан зээлдүүлэх байгууллагуудад эрсдэлийн шинжилгээ үнэлгээ хийх, төслийн хэрэгжилтийг дамжуулан зээлдүүлсэн зээлээр төлөх боломжтой эсэхийг хянах тухай тус тус журамд тусгасан.

Зорилт 3. Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, зах зээлийн

нээлттэй, өрсөлдөөнт, хүртээмжтэй байдлыг хангаж, Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулна.

3.1 дэх арга хэмжээ: Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгов.

Сангийн яамны зүгээс Засгийн газрын гадаад үнэт цаасны арилжааг нэгдсэн цахим системээр явуулах ажлын хүрээнд “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын “Журам батлах тухай” 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолоор батлуулсан. Мөн Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 280 дугаар тушаалаар “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үнэ, өгөөж, хүү тооцох болон арилжааны хуваарилалтыг хийх, Засгийн газрын дотоод үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс буцаан худалдан авах аргачлал”-ыг тус тус шинэчлэн боловсруулан баталсан.

Дээрх журам болон аргачлал батлагдсанаар Засгийн газрын дотоод үнэт цаасны үйл ажиллагааг зохицуулж байсан 3 журмыг хүчингүй болгож, Засгийн газрын үнэт цаасыг олон нийтэд нээлттэй, тэгш хүртээмжтэй, өрсөлдөөнт зарчмаар явуулах эрх зүйн нэгдсэн тогтолцоог бий болж байгаа ач холбогдолтой.

3.2 дахь арга хэмжээ: Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг хөгжүүлсэн.

Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны зах зээл нь өмнө нь бөөний болон жижиглэнгийн зах зээлээс бүрдэж байсан бөгөөд бөөний зах зээл дээр арилжааны банкнууд Монголбанкны банк хоорондын цахим арилжааны системийг ашиглан өрсөлдөөнт арилжаанд оролцон жигнэсэн дундаж хүүг тогтоож байсан бол жижиглэнгийн зах зээл нь бөөний арилжаанаас тогтсон жигнэсэн дундаж хүүтэй өрсөлдөөнт бус арилжаанд иргэд, аж ахуйн нэгжээс брокер дилерийн компаниудаар дамжуулан санал авч, Хөрөнгийн биржийн арилжааны системээр явагдаж байсан.

Нийт үнэт цаасны 87.8 хувийг Монголбанкны бөөний арилжаа, 12.2 хувийг МХБ-ын жижиглэнгийн арилжаа тус тус эзэлж байсан. Нээлттэй хэлбэрээр арилжаалсан үнэт цаасны 82.1 хувийг дотоодын арилжааны банкнууд, 9.4 хувийг дотоодын бусад аж ахуйн нэгжүүд, 6.7 хувийг гадаадын аж ахуйн нэгж, 1.5 хувийг дотоодын иргэд, 0.2 хувийг гадаадын иргэд тус тус худалдан авсан байна.

ЗГДҮЦ-ны бөөний болон жижиглэнгийн арилжааны дэд бүтцийг нэгтгэн нэг арилжааны сувгаар арилжаалах, арилжааг ил тод, шударга, зардал болон шат дамжлага багатай, иргэд аж ахуй нэгжүүдэд хүртээмжтэйгээр явуулах, хөрөнгийн зах зээлийн бэнчмарк жишиг хүүг өрсөлдөөнт арилжааны үр дүнд багаар тогтоох зорилгоор “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг Өрийн удирдлагын тухай хуульд нийцүүлэн шинэчлэн Засгийн газрын 2019 оны 77 дугаар тогтоолоор баталсан.

Дэлхий нийтийн чиг хандлага санхүүгийн үйлчилгээг хямд, хялбар, шуурхай, хүртээмжтэй болгох зорилгоор блокчейн технологийг санхүүгийн үйлчилгээнд нэвтрүүлэх нь түгээмэл болж байна. Улмаар 2018 оны “Монголын эдийн засгийн форум” дээр Монголын дотоодын технологийн компани нь блокчейн технологи дээр суурилсан үнэт цаасны арилжааны платформыг зохион бүтээснийг танилцуулсан. Энэхүү цахим арилжааны систем нь үнэт цаасны арилжааг хөрөнгө оруулагчдад хүртээмжтэй, зардал багатай, шат дамжлагагүйгээр явуулах боломжийг зах зээлийн оролцогчдод олгох юм.

Засгийн газрын бөөний болон жижиглэнгийн арилжааны дэд бүтэц нь иргэд аж ахуйн нэгж арилжаанд оролцоход шат дамжлага ихтэй, мөн шимтгэл хураамжийн зардал харьцангуй өндөр байгаа нь зах зээлийн дэд бүтцийг шинэчлэн сайжруулах шаардлага бий болсон.

Сангийн яамны зүгээс дотоод үнэт цаасны арилжаанд оролцоход гардаг дээрх хүндрэлүүдийг багасгах, иргэд, аж ахуйн нэгжийн арилжааны идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор блокчейн технологийг ашигласан арилжааны шинэ системийг улам боловсронгуй болгох ажлыг Улаанбаатар хөрөнгийн бирж ХХК-тай хамтран 2021 онд хийж дууссан.

1.3 Засгийн газрын дотоод үнэт цаасны үр ашиг, эрсдэлийн талаарх иргэн, аж ахуйн нэгжид чиглэсэн мэдлэг дээшлүүлэх арга хэмжээг авна.

Засгийн газрын өрийн удирдлагын стратегийн хэрэгжилтийн хугацаанд Засгийн газрын дотоод үнэт цаасны талаар олон нийтийн сүлжээнд богино хэмжээний бичлэгийг олон нийтэд нээлттэй байдлаар байршуулсан бөгөөд BONDS.MN вэбсайтыг хөгжүүлсэн. Тус вэбсайтаар дамжуулан иргэн, аж ахуй нэгжид чиглэсэн мэдээллийг товч тодорхой байдлаар хүргэж байна.

Зорилт 4. Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.

4.1 дэх арга хэмжээ: Засгийн газрын өрийн баталгаа, “барих-шилжүүлэх” төрлийн концесс, өрийн бичиг зэрэг өрийн хэрэгслээр өр үүсгэхгүй байх бодлогыг баримталсан.

Засгийн газрын зүгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн баталгааны хэмжээг нэмэгдүүлэхгүй байх, “барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээ, өрийн бичгээр болзошгүй өр төлбөр үүсгэхгүй байх бодлогыг Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд баримталж ажилласан. Үүний хүрээнд Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах болон аливаа хүсэлтэд татгалзсан хариу өгч ажилласан бөгөөд мөн Засгийн газрын зүгээс шинээр “барих-шилжүүлэх” төрлийн концессын гэрээг 2017 оноос хойш байгуулаагүй.

Засгийн газрын зүгээс баталгаанаас үүсэх болзошгүй өр төлбөрийг багасгах, Засгийн газрын өрийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг бууруулах

зорилгын хүрээнд өрийн баталгаа нэмж гаргахгүй байх бодлогыг хэрэгжүүлсээр байна.

4.2 Засгийн газрын өрийн баталгаа, батлан даалттай төслүүдэд эрсдэлийн үнэлгээ тогтмол хийх тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлнэ.

Засгийн газрын өрийн баталгаатай холбоотой харилцааг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 146 дугаар тогтоол, Сангийн сайдын 2015 оны 94 дүгээр тушаалаар баталсан журмаар зохицуулж байсныг нэгтгэн, нэг эрх зүйн актаар зохицуулах нь ӨУТХ-ийн 35.6, 35.10-т нийцэж байсан тул “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавих шаардлага, авлага барагдуулах журам”-ыг 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 210 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. Дараах журмын зохицуулалтыг нэгтгэж шинэчилснээр Засгийн газрын баталгаа бүхий төсөл, арга хэмжээнд жил бүр эрсдэлийн үнэлгээ хийх, баталгаа гаргуулагчийн хувьд үүсэж болох байгууллагын эрсдэлээс сэргийлэх зэрэг өөрчлөлтийг хийсэн. Дараах журмын зохицуулалтыг нэгтгэж шинэчилснээр Засгийн газрын баталгаа бүхий төсөл, арга хэмжээнд жил бүр эрсдэлийн үнэлгээ хийх, баталгаа гаргуулагчийн хувьд үүсэж болох байгууллагын эрсдэлээс сэргийлэх зэрэг өөрчлөлтийг хийсэн.

Түүнчлэн, энэ хүрээнд Засгийн газрын өрийн баталгаат зээл авч ашигласан 2 байгууллага болох “Эрдэнэс Монгол” ХХК болон Монгол Улсын Хөгжлийн банкны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд эрсдэлийн үнэлгээг хийж Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.

4.3 Бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах баталгаа гаргах, концессын төлбөрийг төлөх баталгааны захидал олгох зэргээр шууд бусаар болзошгүй өр, төлбөр үүсгэж байгааг хянах, оновчтой удирдах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Засгийн газрын өрийн баталгаатай холбоотой харилцааг Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 146 дугаар тогтоол, Сангийн сайдын 2015 оны 94 дүгээр тушаалаар баталсан журмаар зохицуулж байсныг нэгтгэн, нэг эрх зүйн актаар зохицуулах нь ӨУТХ-ийн 35.6, 35.10-т нийцэж байсан тул “Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавих шаардлага, авлага барагдуулах журам”-ыг 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 210 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан.

Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль заасан хязгаарын хүрээнд энэ хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас, баталгаа гаргах” гэж заасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2021 оны 311 дүгээр тогтоолоор газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх үүрэг хүлээсэн аж ахуйн нэгжүүдийн Оросын Холбооны Улсын “Роснефт НХН”-ээс АИ-92 автобензин худалдан авах зориулалтаар ондоо эргэн төлөгдөх нөхцөлтэй арилжааны банкуудаас авах зээлийн эргэн төлөлтөд Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын

20-ны өдрийн “Засгийн газрын өрийн баталгаа гаргах тухай” 160 дугаар тогтоолыг батлуулсан.

Бүтээгдэхүүний хил үнийн өсөлтөөс үүдэн өргөн хэрэглээний АИ-92 автобензинийн жижиглэнгийн үнэ 2022 оны 04 дүгээр сард өнөөдрийн зарагдаж байсан 2390 төгрөг дээр 900 орчим төгрөгөөр нэмэгдэх нөхцөл байдал үүссэн бөгөөд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ОХУ-ын Роснефть НХН-тэй хэлэлцээр хийж АИ-92 автобензинийн хил үнэ 1110 тонн/ам.долларыг 840 ам.доллар болгон бууруулсан бөгөөд энэхүү хэлэлцээрийн гол нөхцөл нь 4, 5, 6 дугаар саруудын нийт хэрэглээ буюу 120.0 мянган тонн бүтээгдэхүүний захиалгын төлбөр болох 100,800,000.0 ам.доллартой тэнцэх хэмжээний эх үүсвэрийг урьдчилан төлөх нөхцөлтэй юм.

Дээрх баталгаат зээлийн хөрөнгийг автобензин импортлогч байгууллагууд нь арилжааны банкнаас зээлэх бөгөөд тус зээлийн эх үүсвэрийг Монголбанк арилжааны банкуудад “Репо” санхүүжилтийн нөхцөлөөр олгосон бөгөөд “Роснефть” НХН-ийн Монгол Улс дахь Голомт банкны данс руу шилжүүлснээр “Засгийн газрын өрийн баталгаа”-ны гэрээ хүчин төгөлдөр болж, 2022 оны 09 дүгээр сард баталгаа гаргуулсан байгууллагууд Арилжааны банкнаас авсан зээлээ төлж барагдуулж гэрээний үүргийг бүрэн биелүүлсэн.

4.4 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8.б-д заасан Засгийн газрын өрийн баталгааны хэмжээг 2018 оноос нэмэгдүүлэхгүй байх бодлогыг баримтална.

Монгол Улсын Засгийн газрын өрийн баталгааны үлдэгдэл 2021 оны жилийн эцсийн байдлаар 876.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар 812.9 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа нь хууль болон гэрээнд заасны дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгааны дүнг нэмэгдүүлээгүйг илтгэж байна.

4.5 Олон улсын санхүүгийн байгууллагуудаас санал болгож байгаа болзошгүй эрсдэлээс сэргийлэх, зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлнэ.

Болзошгүй эрсдэлээс сэргийлэх, зээлийн шугамыг ашиглах механизмыг нэвтрүүлэх ажлын хүрээнд Дэлхийн банк, Япон улсын Жайка, Германы Сэргээн Босголтын Зээлийн Банк гэх байгууллагуудтай тус тус уулзалтыг зохион байгуулсан. Тухайлбал зээлийн шугамыг ашиглах механизмын талаарх Дэлхийн банкнаас Зүүн Ази, Номхон далайг хариуцсан зөвлөхүүдтэй 2021 оны 11 дүгээр сарын 10 өдөр уулзалт хийн, Монгол Улсын нөхцөл байдлын тайлбарлан, Дэлхийн банкнаас санал болгож буй шатаахууны үнийн, нарийн ногоо болон бусад барааны эрсдэлийн удирдлагын талаарх санхүүгийн хэрэгслийн мэдээллийг дэлгэрэнгүй авсан. Дэлхийн банкны зүгээс Монгол Улсын нөхцөл байдал дээр шинжилгээ хийж байгаа бөгөөд, боломжит санхүүгийн хэрэгслийн талаарх уулзалтыг ойрын хугацаанд хийхээр төлөвлөж байна. Япон улсын Жайка байгууллагад тус санхүүгийн

хэрэгслийн талаарх мэдэгдлийн Жайка-гийн Монгол дахь суурийн төлөөлөгчид хүргүүлсэн. Мөн Германы Сэргээн Босголтын Зээлийн Банктай ногоон зээлийн своп болон бусад санхүүгийн хэрэгслийн талаарх уулзалтыг 2021 оны 9 дүгээр сарын 7 өдөр, 2022 оны 02 дугаар сарын 16 өдөр тус тус хийн, албан хүсэлтийг харилцан тохиролцсоны дагуу албан бичгээр явуулахаар шийдвэрлээд байна.

Зорилт 5. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх.

5.1 дэх арга хэмжээ Засгийн газрын өрийн удирдлагын одоогийн нөхцөл байдлыг олон улсын байгууллагаар үнэлүүлэн, уг үнэлгээнд үндэслэн Өрийн удирдлагын тогтолцооны болон үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Сангийн яамны зүгээс юуны түрүүнд Засгийн газрын өрийн удирдлагын одоогийн нөхцөл байдлыг холбогдох олон улсын байгууллагаар үнэлүүлэн, уг үнэлгээг үндэслэн Өрийн удирдлагын тогтолцооны болон үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүний хүрээнд Дэлхийн банкны өрийн удирдлагын гүйцэтгэлийн үнэлгээ (DEMPA)-г 2019 оны байдлаар хийлгүүлэхээр 2019 оны 9 дүгээр сард хүсэлт тавьсны дагуу Дэлхийн банкны ажлын хэсэг 2020 оны 1 дүгээр сард Монгол Улсад ирж ажилласан бөгөөд ажлын хэсгийн дүгнэлт 2020 оны 6 дугаар сард гарсан.

Тус ажлын хэсгийн DEMPA үнэлгээний дүгнэлтийг үндэслэн Сангийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 188 дугаар тушаалаар “Өрийн удирдлагын тогтолцооны болон үйл ажиллагааны хөгжлийн төлөвлөгөө” болон тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдамжийг боловсруулан баталсан. Тус төлөвлөгөөнд олон улсын байгууллагын үнэлгээний дагуу хэрэгжүүлэх шаардлагатай 14 бүрэлдэхүүн хэсгийн хүрээний 94 арга хэмжээг тусгасан бөгөөд 2020-2022 оны хооронд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Өрийн удирдлагын хууль эрх зүйн орчин, бодлого, стратеги, бүртгэл тайлагналт, хөрөнгө оруулагчидтай харилцах харилцаа дээрх 14 бүрэлдэхүүн хэсэг сайжрах, улмаар дотоодын болон олон улсын зах зээлээс хямд нөхцөлтэй эх үүсвэр татах нөхцөл бүрдэх, мөнгөний болон төсвийн бодлого, өрийн удирдлагын уялдаатай байдал сайжрах зэрэг олон эерэг үр дүнг үзүүлнэ.

2. Үр дүнгийн тоон үзүүлэлтүүдийн хэрэгжилт, зардал эрсдэлийн шинжилгээ

Засгийн газрын өрийн багцад хийсэн зардал эрсдэлийн шинжилгээний үр дүнг дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт № 2. Засгийн газрын өрийн багцын шинжилгээ

| Үзүүлэлт | Түвшин | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|----------------------------|-----------|------|------|------|------|
| Өрийн зардал | | | | | |
| Жигнэсэн дундаж хүү (хувь) | Гүйцэтгэл | 4.2 | 3.2 | 3 | 3.4 |
| | Дээд | 4.3 | 4 | 3.8 | 3.6 |
| | Доод | 3.9 | 3.7 | 3.5 | 3.4 |

| | | | | | |
|---|-----------|------|------|------|------|
| Дахин санхүүжилтийн эрсдэл | | | | | |
| Засгийн газрын өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа /жил/ | Гүйцэтгэл | 8.6 | 8.9 | 8.4 | 8.6 |
| | Дээд | 8.6 | 8.1 | 8.7 | 8.6 |
| | Доод | 8.5 | 7.9 | 8.3 | 8 |
| Хүүгийн эрсдэл | | | | | |
| Засгийн газрын өрийн хүү шинэчлэгдэх дундаж хугацаа /жил/ | Гүйцэтгэл | 7.7 | 7.6 | 7.5 | 7.5 |
| | Дээд | 7.7 | 8 | 8 | 8.4 |
| | Доод | 7.7 | 7.6 | 7.6 | 7.4 |
| Ханшийн эрсдэл | | | | | |
| Гадаад валютаар илэрхийлсэн өр /нийт өрд эзлэх хувь/ | Гүйцэтгэл | 93.7 | 95.6 | 97.5 | 95.4 |
| | Доод | 90 | 90 | 88 | 86 |

3.2.1 Өрийн зардал

Стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн хугацаанд буюу 2019-2022 онд хүүгийн түвшин өндөр Засгийн газрын дотоод үнэт цаасыг нээлттэй зах зээлд арилжаалаагүй бөгөөд хөнгөлөлттэй зээл болон хүүгийн түвшин багаар хаалттай үнэт цаас арилжаалж төсвийн алдагдлыг нөхөх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх бодлого баримталсан.

Түүнчлэн өндөр хүү бүхий Мазаалай, Гэрэгэ болон Чингис бондуудыг бага хүүтэй Сенчири, Номад бондоор дахин санхүүжүүлснээр өрийн багцын жигнэсэн дундаж хүү 2019 онд 4.2 хувь байсан бол 2020 онд 3.2 хувь, 2021 онд 3.0 хувь, 2022 онд 3.4 хувь болж тус тус буураад байна.

3.2.2 Дахин санхүүжилтийн эрсдэл

Богино хугацаат арилжааны зээлийн эх үүсвэр авч ашиглахаас татгалзаж, урт хугацаат хөнгөлөлттэй зээл авч ашиглан, Засгийн газрын дотоод үнэт цаас гаргалгүй, хугацаа тулаад байсан гадаад үнэт цааснуудыг 7-10 жилийн хугацаатай үнэт цаасаар дахин санхүүжүүлснээр Засгийн газрын өрийн эргэн төлөх дундаж хугацаа 2018 онд 8.2 жил байсан бол 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 8.6 болж өссөн байна.

3.2.3 Хүүгийн эрсдэл

Засгийн газрын өрийн хүү шинэчлэгдэх дундаж хугацаа 2018 онд 7.6 жил байсан бол 2019-2021 онуудад өрийн удирдлагын зорилтот түвшинг хангасан бөгөөд 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 7.5 болж буурсан байна.

3.2.4 Ханшийн эрсдэл

Засгийн газрын дотоод үнэт цаасыг 2017 оноос эхлэн арилжаалаагүй, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилгоор авсан зээллэгүүд нь гадаад валютаар илэрхийлэгдсэн, түүнчлэн Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалаагүй тул гадаад валютаар илэрхийлсэн өрийн өрийн баталгаа болон барих-шилжүүлэх концессоос бусад Засгийн газрын өрд эзлэх хувь 2019 онд 93.7 хувь байсан бол 2020 онд 95.6 хувь, 2021 онд 97.5, 2022 онд 95.4 хувьтай тэнцэж байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2023-
2025 ОНЫ СТРАТЕГИЙН БАРИМТ БИЧГИЙН
2023 ОНЫ 3-Р УЛИРЛЫН БАЙДЛААРХ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БАГЦЫН ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТОТ БҮТЭЦ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Засгийн газрын зүгээс “Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг”-ийг боловсруулж үндсэн 6 зорилтыг дэвшүүлсэн.

Зорилт 1. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, гадаад зээлийн өрийн үйлчилгээний төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулна.

1.1 Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах:

Засгийн газар хөгжлийн түншүүдтэй хөгжлийн хамтын ажиллагааны дунд хугацааны стратегийг тохиролцон Засгийн газрын шугамаар гадаад улс, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас зээл авахдаа зээлийн ерөнхий хэлэлцээр байгуулагдсан, тусгайлсан зээлийн хэлэлцээрээр эх үүсвэр баталгаажсан, эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээ байх шаардлагыг тавьж, үргэлжилж буй төслүүдийн хувьд тухайн жилд дуусгавар болох төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бүрэн тусгах, тэргүүлэх ач холбогдолтой, амжилттай хэрэгжиж буй төсөл, арга хэмжээг дэмжих зарчмыг баримтлан ажиллаж байна.

Энэ хүрээнд Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-аар соёрхон батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, инженерийн дэд бүтэц, агро-парк байгуулах, үйлдвэрлэлийг дэмжих санхүүжилтийн механизмыг боловсруулж, санхүүжилтийн хэрэгцээг хангаснаар импортыг бууруулж, экспортыг нэмэгдүүлэх зорилготой болно.

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк, Уур амьсгалын ногоон сан болон Европын хөрөнгө оруулалтын банкны хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж болон Монгол Улсын Засгийн газрын оролцоотойгоор нийт 735.0 сая ам.долларын санхүүжилтээр 17 аймаг, 52 байршилд хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Түүнчлэн, Азийн хөгжлийн банкнаас ирэх жилүүдэд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсад 655.0 сая ам.долларын санхүүжилтийн эх үүсвэрийг хуваарилж, Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээрийг амжилттай байгуулсан бөгөөд Улсын Их Хурлаар 2023 оны 06 дугаар

сарын 09-ний өдөр соёрхон батлуулсан. Тус Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийн хүрээнд эдийн засгийн бодит өсөлтийг нэмэгдүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд нийт 191.7 сая ам.долларын санхүүжилтээр дараах 3 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. Хилийн үр бүтээмжийг сайжруулж тогтвортой худалдааг дэмжих төсөл;
2. Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх төсөл (дамжуулах шугам) буюу (Эрдэнэбүрэн-Мянгад эрчим хүчний дамжуулах шугам);
3. Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил /II үе шат/ төсөл зэрэг төслүүд болно;

Зорилт 2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж, дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

2.1, 2.2. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх, өрийн зохицуулалтын арга хэмжээ, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

Дахин санхүүжилтийн арга хэмжээний хүрээнд 2023 оны 01-р сард Сенчири-2 өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж нийтдээ 650 сая ам.доллартой тэнцэх гадаад үнэт цаасыг дахин санхүүжүүлсэн бөгөөд “Гэрэгэ” бондын 435.3 сая ам.долларыг, “Хуралдай” бондын 207.5 сая ам.долларын төлбөрийг тус тус шийдвэрлэсэн.

Гадаад үнэт цаасны төлбөрийг мөнгөн хөрөнгийн хуримтлалаас боломжит хэмжээгээр төлөх арга хэмжээний хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр эргэн төлөгдөх хуваарьтай Чингис бондын үлдэгдэл 136.8 сая ам.долларыг 2022 оны 12 дугаар сарын 5-ны өдөр , Гэрэгэ бондын үлдэгдэл төлбөр болох 82.0 сая ам.долларыг 2023 оны 04 дүгээр сарын 28 -ны өдөр гадаад валютын албан нөөцөд дарамт учруулахгүйгээр тус тус улсын төсвөөс төлж дуусгах үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн.

2.3. Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах үүднээс зэрэглэл тогтоогч байгууллага, хөрөнгө оруулагчдыг мэдээллээр тогтмол ханган хамтарч ажиллах;

Засгийн газрын зүгээс 2023 оны 06 дугаар сард олон улсын хөрөнгө оруулагчидтай роудшоу уулзалт (non deal roadshow) зохион байгуулсан. Энэхүү уулзалтын гол зорилго нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, Монгол Улсын Хөгжлийн банкны үнэт цаасны эргэн төлөлт болон Хуралдай бондын эргэн

төлөлтийн талаар мэдээллийг хүргэсэн бөгөөд хөрөнгө оруулагчдын саналыг сонсох байсан.

Түүнчлэн, 2023 оны 05 дугаар сард олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлагийн төлөөлөлтэй, 07 дугаар сард Эс энд Пи агентлагийн төлөөлөлтэй тус тус уулзалтыг зохион байгуулж, зээлжих зэрэглэл тогтоолгосон бөгөөд Монгол Улсын 2023 оны зээлжих зэрэглэлийг В тогтвортой түвшинд хэвээр хадгалаад байна. Мөн цаашид зээлжих зэрэглэлээ нэмэгдүүлэхэд дараах нөхцөлийг тавьсан болохыг мэдэгдсэн. Үүнд:

- ГВАН-ийг их хэмжээгээр нэмэгдүүлж, Засгийн газрын гадаад өрийн удирдлагын стратегийг хэрэгжүүлж, гадаад санхүүжилтийн хэрэгцээг бууруулж тогтвортой байдлыг хадгалах;
- Макро эдийн засгийн зөв, зохистой бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, түүхий эдийн үнийн болон олон улсын эдийн засгийн савлагаанд хэт мэдрэг байдлыг бууруулж, гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирэхэд таатай бизнесийн орчныг бүрдүүлэх;
- Засгийн газрын өрийн ДНБ-тэй харьцах харьцааг тогтмол бууруулах;
- Монгол Улсын эдийн засаг таамаглаж байгаагаас илүү буюу ижил орлоготой улс орнуудтай харьцуулахад сайжрах;
- Эдийн засгийн өсөлт хүлээлтээс давж өссөн тохиолдолд энэ нь төсөв, өр, гадаад зах зээлийн үзүүлэлтийг хурдан сайжруулах;
- Монгол Улсын тогтолцооны шинэчлэл, сайжруулалт хийх, ялангуяа бодлого боловсруулахдаа бодит ахиц дэвшил гаргах зэрэг болно.

Зорилт 3. Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, Засгийн газрын өрийн багц дахь зах зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор үүсмэл арга хэрэгслийг өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

3.1 Дэлхий нийтэд тулгараад байгаа нь инфляцын өсөлтөөс шалтгаалан гадаад зах зээлд бий болоод байгаа хүүгийн өсөлтөөс хамааран урт, дунд хугацаанд Засгийн газрын гадаад зээлийн хөвөгч хүү өсөх тохиолдолд тогтмол хүүтэй зээл авах нөхцөлийг зээлдүүлэгч талд тавьж ажиллах

Засгийн газрын гадаад зээлийг авахдаа зээлийн хөнгөлөлтийн түвшнийг харгалзан үзэж Засгийн газраас гадаад зээл шинээр авах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ зээлдэгч байгууллагатай зээлийн хэлэлцээрт 2023 оны байдлаар 5 хувьтай тэнцэж байгаа хөвөгч хүүг багасгах бодлогыг баримталж ажиллаж байна. Тухайлбал, 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 560.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийн хөрөнгийн 420.0 сая ам.доллартой тэнцэх хэмжээний зээлийг тогтмол хүүтэй, үлдсэн 140 сая ам.долларыг хөвөгч хүүтэй нөхцөлтэйгөөр авч ашиглах болгож зээлийн нөхцөлийг сайжруулаад байна.

3.2 Орон нутгийн засаг захиргааны өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх, Засгийн газрын өрийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх талаар хамтран ажиллах

Өрийн удирдлагын тухай хуулийн 28¹ дүгээр зүйлийн 28^{1.7} дахь хэсэгт “аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Засгийн газарт баталж мөрдүүлнэ” гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 199 дүгээр “Журам батлах тухай” тогтоолын хавсралтаар “Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журам”-ыг баталж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар дотоодын зах зээлд үнэт цаас гаргах эрх зүйн орчныг бүрдүүлж өгсөн болно.

Зорилт 4. Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, үнэт цаасны арилжааг тогтмолжуулна.

4.1 Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжаанд орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан арилжааны систем нэвтрүүлэх;

ЗГДҮЦ-ыг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах арга хэмжээг төлөвлөн ЗГДҮЦ-ны арилжааны шинэ системийн загварыг хөгжүүлэн туршилтын шатандаа явж байна. Энэхүү арилжааны систем нь хөрөнгө оруулагч нарт ашиглахад хялбар, ойлгомжтой байхаас гадна системийн аюулгүй байдлыг бүрэн хангасан дотоод систем байна.

4.2 Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээл дэх арилжаанд оролцогчдын эрэлтийг нэмэгдүүлэх, хоёрдогч зах зээл дэх үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулах зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасыг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах, зорилтот зах зээлд чиглэсэн Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг зохион байгуулах дэд бүтэц болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх

Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 77 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам”-ын 15 дугаар хэсэгт ЗГДҮЦ-ыг буцаан худалдан авах, хугацаа сунгах, нөхцөл тогтоох тухай заасан байдаг. Түүнчлэн, зорилтот зах зээлд чиглэсэн тендерийн зориулалттай Засгийн газрын дотоод үнэт цаасны талаар судалгааг хийж, ЗГДҮЦ-ыг тендерийн барьцаанд ашиглах тухай дээрх журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулаад байна.

Зорилт 5. Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах, хувийн хэвшлийн компаниудад дэмжлэг үзүүлэх байдлаар Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны зорилтыг хангаж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг хязгаарлана.

5.1 Эдийн засаг болон нийгмийн үр өгөөж өндөртэй төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан, "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцсэн төслүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт Засгийн газрын өрийн баталгаа гаргах замаар дэмжлэг үзүүлэх;

Засгийн газрын зүгээс бэлтгэл ажлаа бүрэн хангасан, зардал-ашгийн тооцоогоор ашигтай гарсан, эргэн төлөгдөх боломжтой "Шинэ сэргэлтийн бодлого"-д туссан төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг Засгийн газрын өрийн баталгаа гаргаж дэмжлэг үзүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд 2023 оны 08 дугаар сарын байдлаар Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлт албан ёсоор ирээгүй байна.

5.2 Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах.

Засгийн газрын өрийн баталгаа гаргасан байгууллагууд болох "Эрдэнэс Монгол" болон Монгол Улсын Хөгжлийн банкны 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтэд эрсдэлийн үнэлгээг хийсэн бөгөөд Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн Төрийн аудитын үйл ажиллагаагаар хянуулж ажилласан.

5.3 Төсвөөс шууд төлөгдөх нөхцөлтэй Барих-Шилжүүлэх төрлийн концессын гэрээ байгуулахгүй, өрийн бичиг /вексель/ шинээр гаргахгүй байх

Засгийн газраас шинээр Барих-Шилжүүлэх нөхцөлтэй концессын төрлийн гэрээ болон өрийн бичиг нэмж байгуулаагүй бөгөөд цаашид стратегийн баримт бичигт заасан арга хэмжээг баримталж ажиллана.

Зорилт 6. Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулна.

6.1 Улирал бүр Засгийн газрын өрийн товхимлыг олон нийтэд ил тод мэдээлэх

Засгийн газрын өрийн статистикийн товхимлыг улирал бүр бэлтгэн Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд олон нийтэд ил тод байдлаар байршуулж байна.

6.2 Улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, мэдээлэх

Улсын секторын өрийн мэдээллийг Төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан 98 хуулийн этгээдүүдээс цуглуулж нэгтгэн хагас жил бүр Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Сангийн яамны цахим хуудсанд олон улсын байгууллагаас тогтоосон стандартын дагуу нийтэд ил тод байдлаар тайлагнаж байна. Түүнчлэн мэдээллийг нэгтгэсэн санг сайжруулах ажлыг зохион байгуулж E-balance санхүүгийн тайлангийн системд тогтсон загварыг үүсгэн байгууллагуудаас мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг боловсронгуй болгосон.